



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/24/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Шинжээч Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Авлага	11
3.5.4 Бараа материал.....	11
3.5.6 Үндсэн хөрөнгө.....	12
3.5.7 Өр төлбөр.....	13
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 01/233
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.НЯМЛХАГВА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан байна. Төв аймгийн Угтаалцайдам сум нь 2023 оныг "бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтыг дэмжих" жил болгон хоршоог хөгжүүлэх жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилго зорилт тавин ажиллаж, дэмжлэг үзүүлснээр тахианы аж ахуй, арьс шир боловсруулах цех, махны цех шинээр байгуулагдан үйл ажиллагаа хэвийн явуулж байна. Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг 94,1 хувьтай, 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг 91,4 хувьтай хэрэгжүүлсэн байна. Аймаг сумын мөрийн хөтөлбөрт тусгагдсан 4 сумыг холбох 122.4 км хатуу хучилттай авто замын төсөл хэрэгжиж, сум доторх 2 км замын ажлыг эхлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сан болон шилжих үлдэгдлээс нийт 59,150.0 мянган төгрөгөөр нийгмийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн байна.

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		935,528.3	1,171,052.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	648,351.8	552,901.7
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	195,239.7	504,707.9
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	91,936.9	113,442.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,130,991.1	1,287,093.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,130,991.1	1,287,093.0
39200	Биет хөрөнгө		1,116,547.4	1,272,650.9
39300	Биет бус хөрөнгө	13	14,443.6	14,442.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,066,519.4	2,458,145.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		9,646.8	7,040.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	9,646.8	7,040.4
41300	Өглөг	17а, 17б	9,646.8	7,040.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,056,872.6	2,451,105.1
51	Засгийн газрын хувь оролцоо		2,056,872.6	2,451,105.1
51100	Засгийн газрын оруулсан капитал		583,063.4	583,063.4
51200	Хуримтлагдсан үр дүн		1,268,331.2	1,662,563.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		205,478.1	205,478.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,066,519.4	2,458,145.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,601,144.7	1,940,230.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО		279,570.9	398,492.7
110	Орлогын албан татвар		191,999.4	288,515.6
1100	Хувь хүний орлогын албан татвар		199,754.0	297,515.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-7,754.6	-9,000.0
113	Хөрөнгийн албан татвар		46,551.1	45,538.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		41,020.4	64,438.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	384,819.3	344,768.3
120	Нийтлэг татварын бус орлого		384,819.3	344,768.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,936,754.5	1,196,969.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,126,706.0	1,534,259.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,976,498.7	1,293,020.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		948,771.0	1,290,628.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		289,152.0	421,249.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		39,799.1	53,098.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		328,871.0	41,629.0
2104	Хангамж, бараа материалын зардал		41,497.4	23,528.4
2105	Нормативт зардал		48,790.8	79,528.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,573.5	0.0
2107	Томилолт, зочны зардал		6,239.7	5,113.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		16,716.4	1,690.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		169,131.0	664,790.7
211	ХҮҮ		0.0	0.0
212	ТАТААС		0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,027,727.7	2,392.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		150,207.3	241,239.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		474,438.7	405,970.5
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0.0	0.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		5,411,498.8	11,738.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-4,937,060.1	394,232.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,319,189.0	1,733,172.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	279,570.9	398,492.7
110	Орлогын албан татвар	191,999.4	288,515.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	199,754.0	297,515.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-7,754.6	-9,000.0
113	Хөрөнгийн албан татвар	46,551.1	45,538.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	41,020.4	64,438.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,550.1	7,435.6
1181	Газрын төлбөр	32,422.0	55,230.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,048.4	1,772.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,863.6	137,710.4
120	Нийтлэг татварын бус орлого	102,863.6	137,710.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,936,754.5	1,196,969.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,956,545.0	1,155,851.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,956,545.0	1,155,851.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	913,998.9	1,153,158.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	280,211.6	422,845.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,265.3	50,320.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	328,106.8	41,629.0
2104	Хангамж, бараа материалын зардал	24,945.9	20,167.5
2105	Нормативт зардал	52,241.5	89,338.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,533.7	12,300.0
2107	Томилолт, зочны зардал	5,819.7	5,113.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,829.8	14,105.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	146,044.5	497,339.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,042,546.0	2,692.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	362,644.1	577,321.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	232,186.7	548,771.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	232,186.7	548,771.5
2200	Дотоод эх үүсвэрээр	232,186.7	548,771.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-232,186.7	-548,771.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-797.0	-124,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	797.0	124,000.0
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.0	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	129,660.4	-95,450.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	518,691.3	648,351.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	648,351.8	552,901.7

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,042,180.5	7,042,180.5
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,056,872.6	2,056,872.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,993,932.7	6,993,932.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-48,247.8	-48,247.8
9	Тайлант үеийн үр дүн	-4,937,060.1	-4,937,060.1
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,056,872.6	2,056,872.6
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,451,105.1	2,451,105.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,056,872.6	2,056,872.6
19	Тайлант үеийн үр дүн	394,232.5	394,232.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,555,716.9	1,631,588.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,135,679.3	1,046,386.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,102,386.7	1,043,694.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,240.3	392,670.2
210101	Үндсэн цалин	370,269.6	345,153.3
210102	Нэмэгдэл	56,303.6	47,516.9
210104	Урамшуулал	- 4,932.9	-
210105	Гэрээт ажлын хөлс	- 4,400.0	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,155.0	46,609.0
210201	Тэтгэврийн даатгал	35,465.4	31,765.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,172.4	3,711.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,337.9	2,946.5
210204	Ажилгүйдлийн даатгал	834.6	739.5
210205	Эрүүл мэндийн даатгал	8,344.7	7,445.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	530,322.0	506,130.1
210301	Гэрэл, цахилгаан	30,837.4	26,303.8
210302	Түлш, халаалт	495,317.7	476,279.7
210303	Цэвэр, бохир ус	4,166.9	3,546.5
2104	Хангамж, бараа материалын зардал	21,055.4	19,937.5
210401	Бичиг хэрэг	2,247.9	2,223.0
210402	Тээвэр, шатахуун	13,227.5	13,227.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,880.0	1,787.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	2,700.0	2,700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,500.0	24,500.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000.0	7,000.0
210604	Урсгал засвар	17,500.0	17,500.0
2107	Томилот, зочны зардал	5,113.0	5,113.0
210702	Дотоод албан томилот	5,113.0	5,113.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	30,778.0	27,515.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	29,500.0	26,345.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	546.0	438.0
210803	Даатгалын үйлчилгээ	300.0	300.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300.0	300.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132.0	132.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,223.0	21,219.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,723.0	18,719.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500.0	2,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,292.6	2,692.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,292.6	2,692.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,292.6	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000.0	2,692.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,270,037.6	461,202.5
221001	Их засвар	765,000.0	284,691.0
222001	Тоног төхөөрөмж	505,037.6	176,511.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	150,000.0	124,000.0
230001	Эргэж төлөгдөх зээл	150,000.0	124,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,555,716.9	1,605,875.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	321,170.0	313,129.9
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	321,170.0	313,129.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,229,904.6	1,260,667.9
320001	Орон нутгийн төсвөөс	1,229,904.6	1,260,667.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	504,642.3	32,077.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000.0	31,747.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	330.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	354,642.3	-
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	500,000.0	-
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	500,000.0	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	118,967.6	94,551.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	118,967.6	34,551.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	110,598.8	34,551.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		29,692.3
210102	Нэмэгдэл		29,692.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх		3,711.6
210201	Тэтгэврийн даатгал		2,523.9
210202	Тэтгэмжийн даатгал		296.9
210203	ҮОМШӨ-ний даатгал		324.4
210204	Ажилгүйдлийн даатгал		59.4
210205	Эрүүл мэндийн даатгал		507.0
2104	Хангамж, бараа материалын зардал		230.0
210402	Тээвэр, шатахуун		230.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	400.0	90.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	400.0	90.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,198.8	827.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,198.8	827.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,368.7	-
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	8,368.7	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		60,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр		60,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		60,000.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	118,967.6	94,551.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,967.6	94,551.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт	118,967.6	94,551.8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Угтаалцайдам сум нь 2023 оныг “бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтыг дэмжих” жил болгон хоршоог хөгжүүлэх жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилго зорилт тавин ажиллаж, хоршоо хөгжүүлэх сангаас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нийт 6 хоршоонд 124,000.0 мянган төгрөгийн зээл олгон, дэмжлэг үзүүлсэнээр тахианы аж ахуй, арьс шир боловсруулах цех, махны цех шинээр байгуулагдан, үйл ажиллагаа хэвийн явуулж байна.

Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг 7 бодлого 98 зорилтын хүрээнд 100 хувьтай 80 арга хэмжээ, 70 хувьтай 17 арга хэмжээ, 40 хувьтай 1 арга хэмжээ буюу 94,1 хувьтай, 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг 7 бодлогын хүрээнд 40 зорилт 119 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр төлөвлөж ажилласнаас хэрэгжилт 91,4 хувьтай тус тус хэрэгжүүлсэн байна. Аймаг, сумын мөрийн хөтөлбөрт тусгагдсан 4 сумыг холбох 122.4 км хатуу хучилттай авто замын төсөл хэрэгжиж, сум доторх 2 км замын ажлыг эхлүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Угтаалцайдам сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас завсрын аудитад хамрагдсан, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг жилд 2 удаа орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагаанд хийж хэвшсэн ба сумын хэмжээнд төлөвлөгөө гарган хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,458,145.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 391,626.1 мянган төгрөгөөр буюу 18,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	648351.8	552901.7	-95450.1
Авлага	195239.7	504707.9	309468.2
Бараа материал	91936.9	113442.9	21506.0
Үндсэн хөрөнгө	1130991.1	1287093.0	156102.0
Нийт хөрөнгийн дүн	2066519.4	2458145.5	391626.1
Өр төлбөр	9646.8	7040.4	-2606.3
Засгийн газрын хувь оролцоо	2056872.6	2451105.1	394232.5
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2066519.4	2458145.5	391626.1

Эх сурвалж: Угтаалцайдам сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 552,901.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 95,450.1 мянган төгрөгөөр буурсан нь орон нутгийн төсвийн харилцах дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 68,467.4 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 92,252.8 мянган төгрөгөөр тус тус буурсан, орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл 66,539.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 504,707.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 309,468.2 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын тамгын газрын авлага орон нутгийн хөрөнгө оруулалтын ажлыг бүрэн гүйцэтгээгүйгээс 163,063.8 мянган төгрөгөөр, ОНХС-ийн авлага 42,000.0 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн авлага 101,349.3 мянган төгрөгөөр тус тус өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 113,442.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,506.0 мянган төгрөгөөр өссөн нь эм эргэлтийн сангийн эмийн үлдэгдэл 16,308.8 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын бараа материалын үлдэгдэл 4,770.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,287,093.0 мянган төгрөг болж, өмнөх оноос - 391,626.1 мянган төгрөгөөр өссөн нь эмийн эргэлтийн сан 4,000.0 мянган төгрөгийн, ЗДТГ нь төсвийн хөрөнгөөр 86,399.7 мянган төгрөгийн, сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 05 дугаар тогтоолоор ЕБС-ийн 218,456.0 мянган төгрөгийн 83,741.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй дотуур байрны барилгыг балансаас балансад шилжүүлж бүртгэсэн, орон нутгийн хөгжлийн сан болон хандив эх үүсвэрээр 80,879.7 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэснийг бүртгэж, сумын ИТХ-ын 2023 оны 05 тоот тогтоолоор 30,313.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан, ЕБС-д 10,000.0 мянган төгрөгийн 65 инч дэлгэцтэй самбарыг шилжүүлсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 2,451,105.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 394,232.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 552,901.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 95,450.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
МӨНГӨН ХӨРӨНГӨ	648,351.8	552,901.7	-95,450.1
Банкинд байгаа бэлэн мөнгө	648,351.8	552,901.7	-95,450.1
Төгрөг	648,351.8	552,901.7	-95,450.1
Төрийн сангийн харилцах	648,284.0	552,474.2	-95,809.9
Арилжааны банк дахь харилцах	67.7	427.5	359.8

Эх сурвалж: Угтаалцайд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 552,901.7 мянган төгрөгийн 53,6 хувь буюу 296,585.7 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 37,4 хувь буюу 206,555.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 4,6 хувь буюу 25,606.3 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл арилжааны банканд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 504,707.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 309,468.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
АВЛАГА	195239.7	504707.9	309468.2
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	317.8	317.8
Бусад авлага	195239.7	504390.1	309150.4
Байгууллагаас авах авлага	20307.6	231703.3	211395.7
Хувь хүмүүсээс авах авлага	174932.1	272686.8	97754.7

Эх сурвалж: Угтаалцайд сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны жилийн эцсийн үлдэгдэл 253,231.7 мянган төгрөгийн 45,9 хувийг буюу 231,703.3 мянган төгрөгийг байгууллагаас авах авлага, 54,0 хувийг хувь хүмүүсээс авах авлага эзэлж байна. Нийт авлагын 52,3 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага, 33,7 хувийг ЗДТГ-ын, 12,3 хувийг Орон нутгийн хөгжлийн сангийн авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

- Наадмын талбайн засвар үйлчилгээг Есөн хэлхээ ХХК-д 125,376.0 мянган төгрөгийг, Азийн баялаг ХХК-д төрийн албан хаагчийн байрны засварт 39,000.0 мянган төгрөгийг шилжүүлж, ажлыг дуусаагүй, хүлээн аваагүй байхад барилга байгууламж дансанд капиталжуулан бүртгэж, тайлагнасан алдааг аудитын явцад залруулж, авлагаар бүртгэсэн.

- 12 дугаар сард олгосон 500.0 мянган төгрөгийн урьдчилгааг суутгаагүй зардалд бичиж тайлагнасныг залруулж авлагаар бүртгүүлж залруулсан.

- Өмнөх оны аудитаар бичигдсэн 2,461.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, мөн 12 дугаар сард олгосон 500.0 мянган төгрөгийн урьдчилгааг суутгаагүй зардалд бичсэн, дансны өмнөх оны авлагын үлдэгдэл 2,470.5 мянган төгрөгийг болон 8 дугаар сард олгосон 200.0 мянган төгрөгийн урьдчилгааг төлүүлээгүй зэрэг нийт 5,631.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 113,442.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 21,506.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
БАРАА МАТЕРИАЛ	91936.9	113442.9	21506.0
Түүхий эд материал	81082.3	98704.2	17621.8
Тусгай зориулалттай материал	44506.9	45819.9	1313.0
Эм боох материал	36575.4	52884.3	16308.8
Хангамжийн материал	5854.5	9738.7	3884.2
Бичиг хэргийн материал	1251.3	2032.5	781.2
Аж ахуйн материал	4018.0	4018.0	0.0
Сэлбэг хэрэгсэл	535.0	3615.0	3080.0
Түлш, шатах тослох материал	50.2	73.2	23.0
Мал амьтад	5000.0	5000.0	0.0

Эх сурвалж: Угтаалцайдам сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 21,506.0 мянган төгрөгөөр өссөн нь эмийн эргэлтийн сангийн эм боох материалын үлдэгдэл 16,308.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн, ЗДТГ нь ОНХС-гаас бэлтгэсэн 11,094.0 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж тайлагнасан нөлөөлсөн байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 113,442.9 мянган төгрөгийн 47,8 хувийг ЗДТГ, 49,7 хувийг эмийн эргэлтийн сан, 2,5 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Аудитын илрүүлэлт

- ЗДТГ нь 2023 онд зарцуулсан 18,704.1 мянган төгрөгийн шатахууны тайлан, жолоочийн тооцоо бодсон баримтыг аудитад ирүүлээгүй.
- Тамгын газрын аудитын түүвэрт хамрагдсан бараа материалын 80 хувь буюу 30,888.0 мянган төгрөгийн материалыг тусгай зориулалттай материалын дансанд буруу ангилан бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох зөвлөмж бичигдсэн.
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны хоол, хүнсний материалын үнэнд 1,403.0 мянган төгрөгийг зарцуулалт, гүйцэтгэлийн тайлан нотлох баримтгүй, материалыг бүртгэж тайлагнаагүй зардалд бичсэн зөрчлийг таслан зогсоох зөвлөмж өгөгдөө.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,287,093.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 156,102.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1130991.1	1287093.0	156,102.0
Биет хөрөнгө	1116547.4	1272650.9	156,103.5
Барилга, байгууламж, орон сууц	698941.3	1024153.0	325,211.7
Хуримтлагдсан элэгдэл	-241920.6	-366893.0	-124,972.4
Авто-тээврийн хэрэгсэл	175838.6	175838.6	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-108800.8	-124265.1	-15,464.2
Машин тоног төхөөрөмж(компьютер)	396294.7	417409.5	21,114.8
Хуримтлагдсан элэгдэл	-131705.9	-157976.2	-26,270.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	75270.3	85534.9	10,264.6
Хуримтлагдсан элэгдэл	-28507.1	-37896.9	-9,389.8
Зам, гүүрийн байгууламж	768255.1	768255.1	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-758255.1	-758255.1	0.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	10000.0	10000.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	285278.4	285278.4	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-82150.5	-106541.3	-24,390.8
Дуусаагүй барилга, байгууламж	58009.0	58009.0	0.0
Биет бус хөрөнгө	14443.6	14442.1	-1.5
Програм хангамж	1675.0	1675.0	0.0
Хуримтлагдсан элэгдэл	-179.4	-180.9	-1.5
Бусад биет бус хөрөнгө	12948.0	12948.0	0.0

Эх сурвалж: Угтаалцайдам сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн 1,287,093.0 мянган төгрөгийн үлдэгдлийн 99,0 хувь буюу 1,274,355.6 мянган төгрөгийг сумын ЗДТГ-ын хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн сан болон шилжих үлдэгдлээс хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж ЭХО аппарат 29,150.0 мянган төгрөгөөр, ЕБС-ийн хүүхдийн сурах орчинг сайжруулан ухаалаг самбар 10,000.0 мянган төгрөгөөр, соёлын төвийн спорт заалны засварыг 20,000.0 мянган төгрөгөөр нийт 59,150.0 мянган төгрөгөөр нийгмийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн байна

Аудитын илрүүлэлт:

- Сумын ОНХС-ийн эх үүсвэрээр Соёлын төвийн 20,000.0 мянган төгрөгийн их засвар, сумын ЭМТ-д 29,150.0 мянган төгрөгийн ЭХО аппарат бэлтгэснийг ЗДТГ-ын үндсэн хөрөнгө дансанд орлого, зарлагаар бүртгэж, шилжүүлсэн алдааг аудитын явцад залруулсан.
- Наадмын талбайн засварт есөн хэлхээ ХХК-д 125,376.0 мянган төгрөгийг, Азийн баялаг ХХК-д төрийн албан хаагчийн байрны засварт 39,000.0 мянган төгрөгийг шилжүүлж, ажлыг дуусаагүй, хүлээн аваагүй байхад барилга байгууламж дансанд капиталжуулан бүртгэснийг аудитын явцад залруулсан.
- ЗДТГ-ын санхүү үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 75,516.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг залруулсан.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 7,040.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,606.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	9646.8	7040.4	-2606.3
Өглөг	9646.8	7040.4	-2606.3
Ажилчидтай холбогдсон өглөг	129.9	0.0	-129.9
Бусад өглөг	9516.9	7040.4	-2476.4
Байгууллагад төлөх өглөг	9516.9	7040.4	-2476.4

Эх сурвалж: Угтаалцайдам сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 6,149.2 мянган төгрөг эмийн эргэлтийн сангийн, 891.2 мянган төгрөг байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сангийн өглөг эзэлж байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,451,105.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 394,232.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Засгийн газрын хувь оролцоо	2056872.6	2451105.1	394232.5
Засгийн газрын оруулсан капитал	583063.4	583063.4	0.0
Хуримтлагдсан үр дүн	1268331.2	1662563.6	394232.5
Өмнөх үеийн үр дүн	6205391.2	1268331.2	
Тайлант үеийн үр дүн	-4937060.1	394232.5	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	205478.1	205478.1	0.0

Эх сурвалж: Угтаалцайдам сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 394,232.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн үзүүлэлттэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ-ын өмч өөрчлөлтийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээг 152,373.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тайлагнасан алдааг аудитын явцад залруулсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Угтаалцайдам сумын 2023 оны төсвийн төсөлд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 416,650.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн жилд зарцуулах зардлыг 1,456,000.0 мянган төгрөг, санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 416,650.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс 1,039,350.0 мянган төгрөг, нийт зарлагыг 1,456,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн орлогыг 23,967.1 мянган төгрөгөөр өсгөж 440,617,1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь орон нутгийн төсвийн орлого тасарахад шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төв аймгийн Угтаалцайдам сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20.-ны өдрийн “Сумын 2023 оны төсөв батлах тухай” 05 дугаар тогтоолоор 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 2,267,187.2 мянган төгрөгөөр баталж, Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 351,860.5 мянган төгрөгөөр баталсаныг ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн “Сумын 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” 01 дүгээр тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 88,756.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 440,617.1 мянган төгрөгөөр, 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг 288,529.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,555,717.0 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 18 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 440,617.1 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 789,287.6 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 321,170.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээс 134,867.6 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 219,774.7 мянган төгрөг, иргэн аж ахуйн нэгж байгууллагаас хандив тусламжийн орлогыг 500,000.0 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 150,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 789,287.6 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын ба татварын бус орлого 403,913.0 мянган төгрөг төвлөрч, орон нутгийн байгууллагуудад 1,260,667.9 мянган төгрөгийг санхүүжилт олгож, тайлант хугацаанд зарцуулаагүй 10,814.5 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж төсвийн тохируулга хийгдсэн байна. Мөн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор тусгай сангийн 36,617.2 мянган төгрөг, эм эргэлтийн сангийн орлого 95,342.8 мянган төгрөг, ОНХС-ийн орлогоор 349,778.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,631,588.6 мянган төгрөг буюу 63,8 хувийн хэрэгжилттэй зарцуулжээ. Цалин, шимтгэлийн зардлаас 30,116.2 мянган төгрөг, тогтмол зардлаас 24,192.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлаас 1,117.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 3,263.0 мянган төгрөг, урсгал шилжүүлгээс 30,600.5 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 808,835,2 мянган төгрөг хэмнэсэн байна.

Цалин шимтгэлийн зардал орон тоо дутуу ажилласнаас, хөрөнгийн зардал хандив тусламжийн орлого 500,0 сая төгрөг төлөвлөсөн боловч хандив төвлөрөөгүй мөн тендер сонгон шалгаруулалттай холбоотойгоор хөрөнгийн зардал хэмнэгдсэн байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр арга хэмжээ	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах сёны байгууллагын үндсэн үйл ажиллагаа	83,839.6	82,466.7	1,372.9	98.4
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын үндсэн үйл ажиллагаа	798,155.5	672,181.7	125,973.8	84.2
3	Ерөнхий боловсрол –тогтмол зардал	262,147.2	261,951.3	195.9	99.9
4	Сургуулийн өмнөх боловсрол -тогтмол зардал	30,884.1	20,992.6	9,891.5	68.0
5	Соёлын үйлчилгээ-тогтмол зардал	166,712.7	162,998.5	3,714.2	97.8
6	Эрүүл мэндийн төв тогтмол зардал	27,940.2	23,758.6	4,181.6	85.0
7	Хоршоо хөгжүүлэх сан үндсэн үйл ажиллагаа	150,000.0	124,000.0	26,000.0	82.7
8	Орон нутгийн хөгжлийн сан хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ	1,036,037.6	283,239.2	752,798.4	27.3
	дүн	2,555,716.9	1,631,588.6	924,128.3	63.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар 85,945.3 мянган төгрөг, ИТХ 8,606.5 мянган төгрөг нийт 94,551.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөр хэрэгжих тайлант хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01-2023.12.31	Сумын ИТХТ, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, Жилд 4-өөс доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангаж ажилласан 98.4 %	83,839.6	82,466.7
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Хэрэгжилт 84.2 %	798,155.5	672,181.7
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01-2023.12.31	Хоршоо хөгжүүлэх сангийн журмыг дагаж мөрдөх	Шаардлага хангасан зээлдэгчдэд 124,0 сая төгрөгийн зээл олгосон Хэрэгжилт 82,7%	150,000.0	124,000.0
4	71802-Ерөнхий боловсролын	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн	Хэрэгжилт 99.9 %	262,147.2	261,951.3
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн	Хэрэгжилт 98,4%	30,884.1	20,992.6
6	71702-Соёлын үйлчилгээ	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн	Хэрэгжилт 97,8 %	166,712.7	162,998.5
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01-2023.12.31	Дулаан, цахилгаанаар бүрэн	Хэрэгжилт 98,9%	27,940.2	23,758.6
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх	Хэрэгжилт 27,3 %	1,036,037.6	283,239.2

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Угтаалцайдам сумын 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 8 дугаар сарын 15 ны өдрийн төсвийн тодотгол баталсан тогтоолыг үндэслэн Сумын Засаг даргын 8 дугаар сарын 16-ны өдрийн 90 тоот захирамжаар 1,504,375.1 мянган төгрөгөөр өөрчлөн баталгаажуулсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орон нутгийн төсвийн урсгал санхүүжилтээр хэрэгжүүлэх арга хэмжээ 8, шилжих үлдэгдэлээс хэрэгжүүлэх төөл арга хэмжээ 4, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ 19, байгаль орчныг нөхөн сэргээх эх үүсвэрээр 6 арга хэмжээ нийт 37 төсөл арга хэмжээ төлөвлөсөн байна. Нээлттэй тендер шалгаруулах 8 хөтөлбөр төсөл арга хэмжээнээс 8 төсөл арга хэмжээг зарласан бөгөөд 1 төсөл арга хэмжээг 3 удаа зарласан боловч оролцогч оролцоогүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт шинжээч Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 23-ний 41 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2023 оны батлагдсан нийт зардал 2,555,716.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 38,335.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 28,751.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд дутуу байршуулсан мэдээллийг нөхөн байршуулах талаар зөвлөв.

Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газар нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдлын хэрэгжилт хангалтгүй 67,4 хувьтай ба өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн албан шаардлага бичигдсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын эхний хагас жилийн орлогын төлөвлөгөөний биелэлтэд завсрын аудит хийгдсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн хэрэгжилтийг фас системд оруулсан байна.

Аймгийн Татварын хэлтэст сумандаа татварын байцаагчтай болгох эсвэл ойр зэргэлдээ сумын байцаагчид хавсруулан ажиллуулж өгөх саналаа 2-3 удаа тавьсан боловч шийдвэрлэгдээгүй тул аймгийн Татварын хэлтэст зөвлөмж өгөх санал ирүүлсэн байна. Одоо Сэргэлэн сумын татварын байцаагч хавсран гүйцэтгэдэг байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	0	2	0	100
Нийт дүн	3	437,771.7	3	437,771.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд дараагийн аудитаар орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл хэрэгжилт, тендер шалгаруулалтыг гүйцэтгэлийн аудитаар шалгах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 38,061.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 зөвлөмж хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн орлогын батлагдсан төлөвлөгөө 440,617.1 мянган төгрөг, гүйцэтгэлээр 403,913.0 мянган төгрөг төвлөрч батлагдсан төлөвлөгөөг 91,7 хувиар биелүүлж, 36,704.1 мянган төгрөгөөр тасалсан, орлогын нэр төрлөөр авч үзэхэд 16 нэр төрлийн орлогоос 9 нэр төрлийг 8,1-99,5 хувиар тасарсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

2. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аудитад ирүүлсэн газрын төлбөр ногдуулалт, төлөлтийн тайлангаар төлбөл зохих нийт төлбөрөөс дутуу төлөвлөсөн, малын тоо толгойн албан татварын тайлант оны 1,357.1 мянган төгрөгийг сумын ОНХС-д төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 60 дугаар зүйлийн 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө үндэслэлтэй төлөвлөж, малын тоотолгойн албан татварыг ОНХС-д төвлөрүүлэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу Төв аймаг дахь

Төрийн аудитын газарт батлагдсан төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны дотор, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	6	457,288.1	1	0	5	457,288.1	5	457,288.1			1	0
ОНХС	1	32,000.0			1	32,000.0	1	32,000.0				
Дүн	7	489,288.1	1	0	6	489,288.1	6	489,288.1			1	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	1	36,704.1					1	36,704.1				
ЗДТГ	4	64,264.2	1	5,631.7	1	18,704.1	2	39,928.4				
Дүн	5	100,968.3	1	5,631.7	1	18,704.1	3	76,632.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ	1	0			1	0		
Дүн	1	0			1	0		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	2	173,296.7	1	8,920.7			1	164,376.0
Засаг дарга	1	1,357.1					1	1,357.1
ИТХ	2	3,928.3	1	2,525.3			1	1,403.0
ЭЭСан	1	204.9	1	204.9				
Дүн	6	178,787.0	3	8,920.7			3	167,136.1
Нийт дүн	7	178,787.0	3	11,650.9	1	0	3	167,136.1